

**УСНЫ ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (эхний хагас жил)	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
		Хэмжээ, сая.төг	Төсвийн эх үүсвэр					
<b>УСНЫ ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО:</b> Монгол Улсын усны нөөцийг нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн иргэд, аж ахуйн нэгжийг баталгаат, хүртээмжтэй усаар хангах, усны хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.								
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ /Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 6.3, 9.2, Монгол улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 3.6.1, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 3.4.1.7, 3.4.2.4, 3.4.2.5, 3.4.3.11, Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын 22.3.1, 22.3.2, 22.3.3 дахь заалт, 2 дугаар хавсралт</b>								
<b>Үйл ажиллагааны 1 дүгээр зорилт:</b> Усны нөөцийг судалж тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, хуримтлуулах, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, хяналт тавих, сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлж, усны мега төслийг хэрэгжүүлэх. /Усны газрын 2025-2028 оны стратегийн үндсэн чиг үүрэг-1/								
	<b>Зорилт 1.</b> Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тогтвортой усны менежментийн тогтолцоог бүрдүүлэх хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх	581.4	Төсвийн тухайн эх үүсвэр	Усны нөөц хамгаалах, хуримтлуулах, судлах арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	50	Усны нөөцийг хамгаалах, хуримтлуулах, судлах чиглэлээр Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь аймагт хөв цөөрөм байгуулах ажлын гэрээг байгуулж хэрэгжилтийг эхлүүлэв. "Онги-Цагаан бургастай" төслийн ТЭЗҮ боловсруулах гэрээ байгуулж, Ганга нуурыг тэтгэх ус дамжуулах байгууламж, хамгаалалтын ойн зурвас, булгийн хамгаалалт, мониторингийн судалгааг хэрэгжүүлэн төслийг 96.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэв. Газрын доорх усны хяналт-шинжилгээний 342 цэгийг улсын нэгдсэн сүлжээнд холбож, 61 бүрэн автомат төхөөрөмж шинээр суурилуулав. Ус ашиглагчдын 4,780 ус авах цэгийг тоолууржуулж, уул уурхайн шүүрлийн 33.1 сая м³ усыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлэв. Баталгаажуулсан 205 дүгнэлтээр үүссэн 206.5 сая м³ хаягдал усны 81 хувийг дахин ашигласан байна.	Зорилтын дундаж үнэлгээ 98 хувь
1	Арга хэмжээ 1.1.Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв цөөрөм шинээр барих, сэргээн засварлах	3,142.3	Улсын төсөв	Шинээр барьсан хөв цөөрмийн тоо	-	Судалгаа хийгдэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	1. "Хөв цөөрөм /Баянхонгор аймгийн Богд сум, Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан сум, Өмнөговь аймгийн Баяндалай сум/" ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн компанитай гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу Баянхонгор аймгийн Богд суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-1 дугаартай 2,550,059,739 төгрөгийн дүн бүхий ажил гүйцэтгүүлэх гэрээг "Эко буянт" ХХК-тай 2026 оны 04 сарын 22-ны өдөр, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-2 дугаартай 240,673,493 төгрөгийн гэрээг "Энх өргөө" ХХК-тай 2026 оны 05 сарын 29-ний өдөр, Өмнөговь аймгийн Баяндалай суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-3 дугаартай 2,169,829,755 төгрөгийн гэрээг "Хүйс нутаг" ХХК-тай 2026 оны 04 сарын 22-ны өдөр байгуулсан. 2. Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улааннуур/ Төсөл арга хэмжээний багц-1: "Орхон-Онги" эко төслийн ТЭЗҮ-г шинэчлэн тодотгох замаар "Онги-Цагаан бургастай" төслийн ТЭЗҮ боловсруулах УТ2601301004 дугаартай 5,398,731,000 төгрөгийн гэрээг "Монхидро констракшн" ХХК-тай 2026 оны 05 сарын 29-ний өдөр байгуулсан.	100
			Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Хашиж хамгаалсан булаг, шандын тоо /өссөн дүнгээр/	162	Улсын хэмжээнд булаг, шанд хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.	Байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд 2025 оны ус рашааны дүн мэдээллийг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын байгаль орчны байцаагч нарын мэдээ бүрдүүлэлтэд хяналт тавьж хуулийн хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Тус мэдээлэлд 330 булаг шандын эхийг хашиж хамгаалсан. Мөн 2026 оны эхний хагас жилд Улсын хэмжээнд 61 булаг шандын эхийг хашиж хамгаалсан.	

2	Арга хэмжээ 1.3.Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Сүхбаатар/-ыг үргэлжлүүлэх	181.4	Улсын төсөв	Усны сан бүхий газрыг бохирдол, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулах төслийн явц, хувь	-	Ажлын гүйцэтгэлийг үргэлжлүүлсэн байна.	Төслийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэгч байгууллагуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллав. Багц 1-ийн хүрээнд Ганга нуур орчмын гидрогеологийн нарийвчилсан зураглал боловсруулж Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Тахилын болон Баянбулагийн эхүүдийг хамгаалж тохижуулах, явган зам, талбай, эргийн тавцан байгуулах ажлыг хэрэгжүүлсэн. Мөн 21 булгийн усанд тогтвортой изотопын шинжилгээ хийлгэж, мониторингийн судалгаа болон эрдэм шинжилгээний ажлуудыг нэгтгэн хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан. Багц 2-т ГН-2 цооногийг ашиглалтын зориулалтад шилжүүлэн тоноглож, Ганга нуурыг тэтгэх ус дамжуулах байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Эцсийн нүүдлээс хамгаалах зорилгоор 2 га талбайд байгальд уусдаг эко торон хамгаалалт суурилуулсан. Багц 3-ын хүрээнд нуурын хойд хэсэгт 9.9 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, нийт 18,000 ширхэг мод тарин дуслын усалгааны систем суурилуулсан. Багц 4 буюу шувуу ажиглах цамхаг байгуулах ажил нь зураг төслийн өөрчлөлтөөс шалтгаалан хойшлогдож, холбогдох хөрөнгө барьцаа дансанд байршаад байна. Төслийн үр дүнд Ганга нуурын усны эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тодорхойлж, усны нөөцийн үнэлгээ, мониторингийн мэдээллийг сайжруулан, экосистемийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдүүлэв. Төслийн нийт 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлж, 2.92 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 96.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. 2026 оны тухайд багц 2 ажлын хүрээнд төлөвлөсөн 181.4 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан.	96
3	Арга хэмжээ 1.5.Усны хэрэглээ, ашиглалтыг тоолууржуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, усны үр ашиг, хэмнэлтийг сайжруулах		Хувийн хэвшил	Ус хэрэглээний тоолуур суурилуулсан аж ахуйн нэгж, байгууллага, /өссөн дүнгээр/	4680	4780	Хоногт 100 шоометрээс их ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагад ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, дүгнэлтийн тавигдах шаардлагад Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах, усны нөөцийг зохистой ашиглах, тоолууржуулахыг даалгаж, биелэлтийг хангах талаар зөвлөмж өгч, аргагүйгээр хангаж ажилласан. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд <b>4780 ш</b> нь ус авах цэг, шугам хоолой бүрийг тоолууржуулж, ус ашиглалтын хэрэглээгээ хянаж байна. Уул уурхайн ухагад хуримтлагдсан шүүрлийн 33.1 сая.м3 усыг уул уурхайн технологи, зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд эргүүлэн ашиглахад 38.0 сая төгрөгийг төлбөрөөс чөлөөлсөн.	100
4	Арга хэмжээ 1.6.Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг зохион байгуулах		Орон нутгийн төсөв,	Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хэрэгжүүлсэн сум, суурин газрын тоо /өссөн дүнгээр/	1	Ажлын даалгавар боловсруулахад мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх, батлуулсан байна.	2026.05.22-ны өдрийн 2026-УГ/03 дугаартай Өмнөговь аймгийн Булган сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын даалгаврыг Усны газрын дарга баталсан.	100
5	Арга хэмжээ 1.7."Цагаан цав" ус хангамжийн төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах	400.0	Орон нутгийн төсөв	Ажлын даалгаврыг хянаж баталгаажуулсан байна.	-	Ажлын даалгаврыг хянаж баталгаажуулсан байна.	Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар "Цагаан цав" газрын доорх усны хайгуул судалгааны ажлын төсвийг батлуулсан бөгөөд нарийвчилсан хайгуулын судалгааны ажлын тендерийг орон нутгаас зарлаж гүйцэтгэгчээр "Мон гидрогео күйст консалтинг" ХХК сонгон шалгарч, 2026.05.18-ны өдөр гэрээ байгуулах, эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлсэн. Гүйцэтгэгч байгууллага нь гэрээ байгуулснаар ажлын даалгавар боловсруулах эрх үүссэн бөгөөд тус ажлын даалгаварт нарийвчлан хийх ажлын тухай санал, зөвлөмж өгч ажиллаж байна. Одоогоор төсөв зарцуулаагүй байна.	90

6	Арга хэмжээ 1.8.Газрын доорх усны ашиглалтын зохистой менежмент явуулах, усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох үүднээс газрын доорх усны хяналт шинжилгээний цэгийг засварлах	-	-	Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон газрын доорх усны хяналт шинжилгээний засварласан цэгийн тоо /өссөн дүнгээр/	124	185	Газрын доорх усны хяналт шинжилгээний 342 цэгийн мэдээллийг www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбогдсон. Газрын доорх усны нэгдсэн сүлжээ www.groundwater.mn цахим хаягийг хөтөлж мэдээллийн баазыг бэхжүүлэх ажил үргэлжилж байна. Монгол орны 21 аймгийн 81 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамарсан 342 цэг ажиллаж байна. Үүнд: - Бүрэн автомат – 88 - Хагас автомат – 252 - Гар хэмжилт – 2 Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах, гэмтэл, засварын тайланг нэгтгэн гаргасан. Усны тухай ууулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-т заасны дагуу дотоодын хяналт шинжилгээний цэгүүдийг Улсын усны мэдээллийн санд холбох зөвлөмж хүргүүлж ажиллаж байна. Туул голын сав газарт хамаарах газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдэд 2026.05.19-2026.05.29-ны өдрүүдэд Монголын мянганы сорилтын сангийн санхүүжилтээр газрын доорх усны хяналт-шинжилгээний 61 бүрэн автомат багаж, тоног төхөөрөмжийг хүлээн авч Улаанбаатар хотод 42 байршилд суурилуулсан. Бусад багаж тоног төхөөрөмжүүдийг суурилуулах боломжтой байршуудын судалгааг хийж байна.	100
7	Арга хэмжээ 1.9.Газрын доорх цэнгэг усыг эрчим хүч, уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах явдлыг хязгаарлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, дахин /эргүүлэн/ ашиглах хэмжээг дүгнэлтээр тогтоох	-	-	Ус ашиглуулах дүгнэлт, Хаягдал усны дүгнэлтээр тооцсон дахин ашиглалтын хувь /өссөн дүнгээр/	80	Дахин ашигласан хаягдал усны хэмжээг 81 хувьд хүргэсэн байна.	Газрын доорх цэнгэг усыг эрчим хүч, уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах явдлыг хязгаарлаж, шүүрлийн болон хаягдал усыг дахин ашиглах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Уул уурхайн ухлагад хуримтлагдсан 33.1 сая м³ шүүрлийн усыг уул уурхайн технологийн үйл ажиллагаа, зам талбай болон ногоон байгууламжийн усалгаанд эргүүлэн ашиглах, гадаргын усыг хуримтлуулан ашиглах, мөн хүн амын унд ахуйн зориулалтаар ашигласан усыг стандартын шаардлагад нийцүүлэн дахин ашиглах талаар ус ашиглуулах дүгнэлт, албан даалгавар, онцгой нөхцөлд тусган хэрэгжилтийг хангуулах чиглэлийг Сав газрын захиргаа болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудад хүргүүлсэн. Усны чанар, шинжилгээний хэлтэст 2026 оны 01 дүгээр сарын 02-ноос 05 дугаар сарын 05-ны хооронд нийт 260 дүгнэлт ирснээс 205 хаягдал усны дүгнэлтийг боловсруулан баталгаажуулсан. Баталгаажуулсан дүгнэлтээр нийт 206.5 сая м³ хаягдал ус үүссэнээс 167.3 сая м³ буюу 81 хувийг дахин ашигласан түвшинд хүрсэн байна.	100
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</b>								
<b>Үйл ажиллагааны 2 дугаар зорилт:</b> Усны нөөцийг зохистой ашиглах бодлогын хэрэгжилтийг хангах, усны нөөцийн дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, ус хэмнэлтийг дэмжиж, мэргэжил арга зүйгээр хангах. /Усны газрын 2025-2028 оны стратегийн үндсэн чиг үүрэг-2/								
<b>Зорилт 2.</b> Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх		-	-	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргалтын хувь	-	85	Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 498 хүсэлтээс 449-ийг шийдвэрлэж, гүйцэтгэл 89.1 хувьд хүрч зорилтот түвшинг хангав. Үүнээс 233 аж ахуйн нэгжид дүгнэлт гаргаж, 133 төсөлд зөвлөмж өгч, 83 хүсэлтийг татгалзсан. Туул голын сав газар, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын менежментийн төлөвлөгөөний тайланг хянаж, сайжруулах зөвлөмж өгч, баталгаажуулан Улсын усны мэдээллийн санд бүртгэн хүлээн авсан.	Зорилтын дундаж үнэлгээ 98 хувь
8	Арга хэмжээ 2.1.Гадаргын болон газрын доорх усны ашиглалтын нөөцийг хянаж ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах	-	-	Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь /өссөн дүнгээр/	100	Ирүүлсэн хүсэлтийн дагуу усны нөөцийн судалгаа, тооцоонд үндэслэн гадаргын болон газрын доорх усны нөөцийг ашиглуулах боломжит хэмжээг тогтоох мэргэжлийн дүгнэлтийг 85-аас доошгүй хувь гаргасан байна.	Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар 498 ААНБ-аас хүсэлт ирүүлснээс одоогоор 449 хүсэлтийг шийдвэрлэж, 49 аж ахуй нэгж байгууллагын усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг боловсруулах, хянуулах төлөвтэй байна. Нийт шийдвэрлэлт 89.1 хувьтай байгаа нь зорилтод түвшинг хангасан байна. Шийдвэрлэсэн хүсэлтүүдийг төрлөөр нь ангилвал: Засварлаж дахин хандуулахаар зөвлөмж өгсөн 133 төсөл, Дүгнэлт гаргах боломжгүй татгалзсан 83 харууг цахимаар хүргүүлж, 233 ААНБ-д дүгнэлт гаргасан байна.	100
9	Арга хэмжээ 2.2.Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах	-	-	Зөвлөмж өгсөн тоо /өссөн дүнгээр/	2	3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/136 дугаар тушаалаар "Туул голын сав газрын менежментийн төлөвлөгөө", "Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын менежментийн төлөвлөгөө"-ний тайланг хянаж, Улсын усны мэдээллийн санд хүлээн авсан. Төлөвлөгөөний тайланг хянан хэлэлцэх явцад усны нөөцийн нэгдсэн менежментийг боловсронгуй болгох, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тодорхой болгох чиглэлээр холбогдох зөвлөмжүүдийг өгсөн. Зөвлөмжийн дагуу тайлангийн агуулга, мэдээллийг сайжруулан боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулан Улсын усны мэдээллийн санд бүртгэн хүлээн авсан.	100

Зорилт 3.Усны нөөцийн судалгаа, тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	-	-	Усны мэдээллийн сангийн бүрдлийн хувь /өссөн дүнгээр/	100	100	Усны нөөцийн судалгаа, тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд ирүүлсэн 4 ажлын даалгаврыг 100 хувь баталж, усны хайгуулын тайланд шинжээч томилон ажиллуулсан. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудаас ирүүлсэн БОХ 2.1, БОХ 2.2 маягтын мэдээллийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд 100 хувь оруулав. Усны улсын тоо бүртгэлээр 6,932 гол мөрөн, 4,732 нуур тойром, 15,165 булаг шанд, 645 рашаан, 350 усан сан, 81,572 худаг бүртгэгдэж, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангагдсан.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь	
10	Арга хэмжээ 3.1.Усны хайгуул, судалгаа, зураг төсөл, төлөвлөгөө, ажлын даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих	-	-	Хийгдсэн ажлын хүрээнд хяналт тавьсан ажлын хувь	100	100	Усны газарт ажлын даалгавар батлуулахаар 4 хүсэлт ирүүлсэн бөгөөд газрын даргын 2026.03.03-ны өдрийн 2026-УГ/01, 2026.03.23-ны өдрийн 2026-УГ/02, 2026.05.22-ны өдрийн 2026-УГ/03, 2026.06.04-ний өдрийн 2026-УГ/04 дугаартай ажлын даалгавруудыг 100 хувь батлуулсан. "Шинжээч томилох тухай" Усны газрын даргын 2026.06.04-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар доктор, зөвөлх инженер, гидрогеологич А.Түвдэндоржийг "Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтод ундны усны гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайлан" -ийн шинжээчээр томилсон.	100
11	Арга хэмжээ 3.2.Улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах	-	-	Мэдээллийн сангийн бүрдлийн хувь	100	100	Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газруудаас Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 тушаалаар зөвшөөрснөөр Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/527 дугаар тушаалаар баталсан БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээлүүдийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд 100 хувь оруулсан. Монгол орны усны тоо бүртгэлийн дүн мэдээгээр: -Нуур, тойром – 4732 -Гол, мөрөн – 6932 -Булаг, шанд – 15165 -Рашаан – 645 -Усан сан, хөв цөөрөм – 350 Худаг – 81572 тоологдсон. Үүнээс Монгол Улсын хэмжээнд 2025 онд гол горхи 97, нуур тойром 104, булаг шанд 309, рашаан 1 буюу нийт 513 гадаргын ус сэргэсэн бол гол горхи 2, нуур тойром 79, булаг шанд 154, рашаан 2 буюу нийт 238 гадаргын ус хатаж ширгэсэн байна. Нийтдээ 21 аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудыг мэргэжил аргагүйгээр ханган ажиллаж байгаль орчны статистик мэдээллийг бүрдүүлсэн.	100
Зорилт 4. Усны эдийн засгийн үнэлгээ, үнэ тариф, нөхөн төлбөрийн тогтолцоог боловсронгуй болгох	-	-	Усны хохирол, нөхөн төлбөр тооцсон дүгнэлтийн хувь	-	85	Усны эдийн засгийн үнэлгээ, нөхөн төлбөрийн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд ус ашиглах зөвшөөрөлгүй үйл ажиллагаатай холбоотой 9 зөрчлийн хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж, усны нөөцөд учирсан 398.9 сая төгрөгийн хохирлыг тооцон Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэхээр хүргүүлэв. Мөн ирүүлсэн бүх хүсэлтийг 100 хувь шийдвэрлэж, ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гарган, "Говийн норов" ХХК-аас 139 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь	
12	Арга хэмжээ 4.1.Усны нөөцөд учруулсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох	-	-	Ирүүлсэн хүсэлтийн дагуу хохирол тооцсон хувь /өссөн дүнгээр/	100	Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хүсэлт болон дотоод хяналт шалгалтын хүрээнд усны нөөцөд учруулсан хохирол тооцсон дүгнэлтийг 85-аас доошгүй хувьд гаргасан байна.	100	
13	Арга хэмжээ 4.2.Аж ахуйн нэгжийн өөрсдөө илрүүлсэн усны нөөцийг бусад хэрэглээнд ашиглуулах нөхцөлд мэргэжлийн дүгнэлт гаргах	-	-	Ирүүлсэн хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь /өссөн дүнгээр/ гаргах	-	Аж ахуйн нэгжийн хэрэгцээнээс илүү гарах усны нөөцийг бусад аж ахуйн нэгжийн хэрэгцээнд ашиглуулах талаар гаргасан дүгнэлт 85 хувиас доошгүй байна.	100	

Зорилт 5. Ус ашиглалтын нэгдсэн мэдээлэл, тайлагнал, хяналтын тогтолцоог сайжруулах	-	-	Ус ашиглалтын тайлангийн тоо	1	2	Усны мэдээллийн нэгдсэн системээр ирүүлсэн хүсэлтүүдийг судлан боловсруулаад усны газрын дүгнэлтийн хурлаар өмнөх оны дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлд хяналтыг тавьж тухай бүр хэлэлцүүлсэн. Мөн сав газрын захиргаад болон аймаг, нийслэлийн БОГ-аас гаргасан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавин, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд Усны газраас нийт 195 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр ногдуулсан усны хэмжээ 408.0 сая.м3, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөрийн хэмжээ 94,278.5 сая.төг СГЗ-аас нийт 73 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр ногдуулсан усны хэмжээ 1.3 сая.м3, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр 259.8 сая төгрөг, аймаг, нийслэлийн БОГ-аас нийт 181 ус ашиглуулах дүгнэлт гаргаж, ногдуулсан усны хэмжээ 554.1 мян.м3 урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр 122.9 сая.төгрөг байна. Орон нутагт 2 удаагийн томилолтоор 2 аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 18 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавин ажилласан байна.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь	
14	Арга хэмжээ 5.2.Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, ус ашиглагчдын хариуцлагыг сайжруулах	-	-	Хяналт тавьсан тоо /өссөн дүнгээр/	-	160	Сав газрын захиргаад болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газраас олгосон 254 Аж ахуй нэгжүүдийн ус ашиглах зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, ус ашиглуулах дүгнэлтийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 7 компани, Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 11 компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хууль, эрх зүйн зөрчил гаргасан 3 компанид усны нөөцөд учруулсан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тооцож хүргүүлсэн. Нийт тавин ажилласан аж ахуйн нэгжийн тоо 272 байна.	100
15	Арга хэмжээ 5.3.Нэг сум-Нэг нуур "333 нуур" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин, холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээллээр хангах	-	-	Тайлангийн тоо /өссөн дүнгээр/	1	2	1. "Хөв цөөрөм /Баянхонгор аймгийн Богд сум, Өвөрхангай аймгийн Хайрхан дулаан сум, Өмнөговь аймгийн Баяндалай сум" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг төрийн худалдан авах ажиллагааны газраас зарлаж, Усны газраас Баянхонгор аймгийн Богд суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-1 дугаартай гэрээг "Эко буянт" ХХК-тай 2026 оны 04 сарын 22-ны өдөр, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-2 дугаартай гэрээг "Энх өргөө" ХХК-тай 2026 оны 05 сарын 29-ний өдөр, Өмнөговь аймгийн Баяндалай суманд хөв цөөрөм байгуулах УТ2601300705-3 дугаартай гэрээг "Хүйс нутаг" ХХК-тай 2026 оны 04 сарын 22-ны өдөр байгуулсан. 2. Голомт банкны санхүүжилтээр Захиалагчаар Сонгинохайрхан дүүргийн засаг дарга, зохицуулагчаар засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, гүйцэтгэгчээр "Престиж Инженеринг" ХХК хамтран Улаанбаатар хотын СХД-ийн 24-р хорооны нутаг дэвсгэрт Бумбатын рашаан, Баруун салааны голыг түшиглэн Бумбатын хөв цөөрөм байгуулах төслийн гэрээг 2026 оны 02 сарын 05-ний өдөр байгуулсан. 2026 оны 05 сарын 25-ны байдлаар ажлын явц 50%. 2026 оны 07 сарын 10-ны өдөр хүлээлгэж өгөхөөр гэрээнд тусгасан. Хөв цөөрмийн эзлэхүүн 16.9 мян.м³. Тус ажлын зураг төсвийг 2025 онд зохиож Барилга хөгжлийн төвөөр магадлал хийлгэсэн. Тус ажлын хүрээнд 2026 оны 05 сарын 22-ны өдөр төсөл хэрэгжүүлж буй байршилд газар дээр нь очиж хяналт тавьж ажилласан. Захиалагчийн хяналтын тайланг гарган хүргүүлсэн.	100
Зорилт 6. Ус ашиглалт, усны нөөцийн зохистой ашиглалт, дүгнэлт гаргалтыг боловсронгуй болгох	-	-	Ус ашиглуулах дүгнэлт гаргасан хүсэлтийн хувь	100	100	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар www.ewater.mn цахим системээр 242 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснээс уул уурхай, хүн амын унд ахуйн усан хангамж, эрчим хүч, барилга, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл зэрэг баримт бичгийн бүрдлийг хангасан ус ашиглуулах дүгнэлтийг боловсруулж, хэлтсийн даргаар хянуулж, дүгнэлтийн хурлаар хэлэлцүүлж нийт шийдвэрлэсэн 195, хянасан 20, боловсруулсан 15 байна. Усны барилга байгууламжийн зураг төслийн дүгнэлт гаргуулах 12 хүсэлт ирүүлснээс Алтны шороон ордын хаягдлын сангийн зураг төсөл 3, Шугам хоолойн зураг төсөл - 3, Нийт зураг төсөлд 6 дүгнэлт гаргасан.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь	

16	Арга хэмжээ 6.1.Гол, мөрний голдирол өөрчлөх, урсгад тохируулга хийх, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах	-	-	Хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь	100	100	Усны барилга байгууламжийн зураг төслийн дүгнэлт гаргуулах 12 хүсэлт ирүүлснээс Алтны шороон ордын хаягдлын сангийн зураг төсөл 3, Шугам хоолойн зураг төсөл - 3, Нийт зураг төсөлд 6 дүгнэлт гаргасан. - Гидро дизайн инноваци ХХК-ийн боловсруулсан "МАК товер" төслийн бохир болон цэвэр ус дамжуулах шугам хоолойн зураг төсөл. - Мөнгөн минж ХХК-ийн боловсруулсан Тэргүүн оюу ХХК-ийн 25 давхар барилгын суурийн шүүрлийн усыг шавхан зайлуулах шугам хоолойн зураг төсөл. - Мөнгөн минж ХХК-ийн боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт Мөнгөн нуруу ХХК-ийн хэрэгжүүлэх MV-022165 тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордын хаягдлын сангийн зураг төсөл. - Гидро сооружение ХХК-ийн боловсруулсан Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт Сонор трейд ХХК-ийн хэрэгжүүлэх MV-001817 тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордын хаягдлын сангийн зураг төсөл. - Эко гидро проект ХХК-ийн боловсруулсан Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Батдөлгөөн мөрөн ХХК-ийн хэрэгжүүлэх MV-005529 тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордын хаягдлын сангийн зураг төсөл. - Эко гидро проект ХХК-ийн боловсруулсан Төв аймгийн Баян сумын нутагт Цэцэнс майнинг ХХК-ийн хэрэгжүүлэх Бөөрөлжүүтийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн шүүрлийн усыг шавхан зайлуулах шугам хоолойн зураг төсөл.	100
17	Арга хэмжээ 6.2.Хоногт 100 м³-ээс дээш ус ашиглах, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр ашиглах, усан тэвэр, эрчим хүчний зориулалттай ус ашиглалтын дүгнэлт гаргах	-	-	Хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь	100	100	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулахаар www.ewater.mn цахим системээр 230 (давхардсан тоогоор 382) аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснээс уул уурхай, хүн амын унд ахуйн усан хангамж, эрчим хүч, барилга, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл зэрэг баримт бичгийн бүрдлийг хангасан ус ашиглуулах дүгнэлтийг боловсруулж, хэлтсийн даргаар хянуулж, дүгнэлтийн хурлаар хэлэлцүүлж нийт шийдвэрлэсэн 195, хянасан 20, боловсруулсан 15 байна.	100
<b>Үйл ажиллагааны 3 дугаар зорилт:</b> Газрын доорх усны нөөц, чанарын хяналт шинжилгээ, гадаргын болон газрын доорх усны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийх, усны бохирдлыг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай тухай хуулийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах замаар усны нөөцийг хомстой, бохирдохоос сэргийлэх. /Усны газрын 2025-2028 оны стратегийн үндсэн чиг үүрэг-3/								
<b>Зорилт 7.</b> Усны нөөц, чанарын төлөв байдлыг судлах, хянах, усны хяналтын төв лабораторийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах		-	-	Усны чанарын хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн хувь	-	85	Усны хяналтын төв лабораторийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах хүрээнд химийн бодис, урвалж, тоног төхөөрөмжийн хангалт, чанарын хяналт, ур чадварын сорилтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэв. 30 багажийн шалгалт тохируулгыг зохион байгуулж, дотоод болон гадаад чанарын хяналтаар хангалттай үнэлгээ авч, лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээний нийцэл 95 хувьтай гарсан. Туул голын 6 цэг болон Хөвсгөл нуурын яаралтай сорьцод хими, микробиологи, хүнд металлын шинжилгээ хийж үр дүнг удирдлагад танилцуулсан. Зорилтод түвшин бүрэн хангагдсан.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь
18	Арга хэмжээ 7.2.Усны хяналтын төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, лабораторийн шинжилгээний чанарыг сайжруулах, усны бохирдлыг бууруулах суурь мэдээлэл бүрдүүлэх	-	-	Ажлын үр дүнгийн хувь /өссөн дүнгээр/	-	Усны хяналтын төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, лабораторийн шинжилгээний чанарыг сайжруулах хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл 85 хувиас багагүй байна.	Лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор 2026 онд химийн бодис, урвалж, микробиологийн шинжилгээний тэжээлт орчин, туслах материалын нийлүүлэлт, аюултай хог хаягдлын устгал, ур чадварын сорилт болон лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээний чиглэлээр холбогдох гэрээндүүдийг байгуулан ажиллав. Лабораторийн 30 багаж, тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын болон шинжилгээний гадаад, дотоод чанарын хяналтын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу чийг, температур хэмжигч 4 багаж, термометр 5 ширхэгийг баталгаажуулж гэрчилгээжүүлэв. Шинжилгээний үр дүнгийн үнэн зөв байдлыг хангах хүрээнд дотоод болон гадаад чанарын хяналтыг тогтмол хэрэгжүүлсэн. ГСШТ-ийн усны ур чадварын сорилтод цэвэр усны химийн 11, хүнд металлын 4 үзүүлэлтээр, ХАБУЛЛ-ийн сорилтод микробиологийн шинжилгээгээр тус тус хангалттай үнэлгээ авч оролцов. Мөн УСУГ-ын Усны төв лабораторитой хамтран хийсэн лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээгээр үр дүнгийн нийцэл 95 хувь буюу 2s үнэмшлийн түвшинд гарсан. Ингэснээр лабораторийн тасралтгүй үйл ажиллагаа хангагдаж, шинжилгээний чанар, үр дүнгийн найдвартай байдал, ажилтнуудын ур чадвар, лабораторийн чадамж сайжирч, зорилтод түвшин бүрэн хангагдсан.	100
		-	-	Удирдлагад танилцуулсан судалгаа, шинжилгээний тайлангийн тоо /өссөн дүнгээр/	2	3	2026 оны 03 сарын 10-нд Туул гол дагуу Баянзүрх, Маршал, Ярмаг, Сонсголон, Сонгино, Биогийн гүүр орчмын хэсгийн 6 цэгээс хяналтын сорьц авч хими, микробиологи, хүнд металлын шинжилгээ хийж бохирдолтой байгааг 2026.03.30-нд удирдлагад танилцуулсан. Мөн 2026 оны 05 сарын 09-нд Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хөвсгөл нуураас ирсэн яаралтай сорьцод хими болон хүнд металлын шинжилгээг хийж 2026.05.10-нд тус тус хийж удирдлагад танилцуулсан.	100

Зорилт 8. Ус бохирдлыг бууруулах, хаягдал усны хэмжээнд хяналт тавин хариуцлагыг сайжруулах.		-	-	Хаягдал усны дүгнэлт, хяналтын гүйцэтгэлийн хувь	-	85	Ус бохирдлыг бууруулах, хаягдал усны хяналтыг сайжруулах хүрээнд 260 хүсэлтээс боловсруулж баталгаажуулсан 205 хаягдал усны дүгнэлтийг хуульд заасан хугацаанд Татварын албанд цахимаар хүргүүлэв. Мөн Бор-Өндөр хотын цэвэрлэх байгууламж болон Эрдэнэт үйлдвэрийн цэвэрлэх байгууламжид хяналт шалгалт хийж, сорьцын шинжилгээ авч, үр дүнг хүргүүлэн зөвлөмж өгч, усны дахин ашиглалтын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Зорилтот түвшин хангагдсан.	Зорилтын дундаж үнэлгээ 98 хувь
19	Арга хэмжээ 8.1.Хоногт 50 шоомтрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид хаягдал усны дүгнэлт гаргах	-	-	Ирүүлсэн хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь /өссөн дүнгээр/	100	Ирүүлсэн хүсэлтийн дагуу хаягдал усны хэмжээ, ус бохирдуулсны төлбөрийг тогтоох мэргэжлийн дүгнэлтийг 85-аас доошгүй хувьд гаргасан байна.	Усны чанар, шинжилгээний хэлтэст 2026.01.02-ноос 2026.05.05 хооронд нийт 260 дүгнэлт гаргуулах хүсэлт ирсэн. Хэлтсийн мэргэжилтнүүдийн боловсруулан, баталгаажуулсан 205 хаягдал усны дүгнэлтийг нэгтгэн, Татварын албанд ажлын 5 хоногийн дотор 1 сард 44, 2 сард 50, 3 сард 25, 4 сард 59, 5 сард 25 дүгнэлтийг 6 сард 2 дүгнэлтийг цахимаар тус тус хүргүүлж ажилласан.	95
20	Арга хэмжээ 8.2.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын урьдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага хүч чадлын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усны стандартын шаардлагыг хангуулах хяналт шалгалт хийх	-	-	Хяналт, шалгалт хийсэн тоо /өссөн дүнгээр/	11	12	2026.04.03-ны өдөр Бор-Өндөр хот тохижилт" ТБАГУТҮГ-ын цэвэрлэх байгууламжид хяналт шалгалт хийж, хяналтын сорьцын шинжилгээ авч, үр дүнг тус байгууллагын удирдлагуудад илгээж, зөвлөгөө өгч ажилласан. 2026 оны 05-р сарын 11-13-ны өдрүүдэд Эрдэнэт үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, усны дахин ашиглалтын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хяналт шалгалтын явцад Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн хаягдлын сантай газар дээр нь танилцаж, савласан усны хяналтын сорьцын шинжилгээ авч, лабораторт өгсөн.	100
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</b> /Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль/								
<b>Үйл ажиллагааны 4 дүгээр зорилт:</b> Салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж, үйл ажиллагааны менежмент, хүний нөөц, гадаад хамтын ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, цахимжилт, дотоод хяналт, шинжилгээ болон төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах. /Усны газрын 2025-2028 оны стратегийн үндсэн чиг үүрэг-4/								
Зорилт 9. Усны нөөцийн мэдээллийн нэгдсэн менежментийг сайжруулах		-	-	Усны мэдээллийн цахим сангийн шинэчлэлтийн хувь	20	30	Усны мэдээллийн нэгдсэн менежментийг сайжруулах хүрээнд улсын усны мэдээллийн сангуудыг тогтмол шинэчилж, ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн 498 хүсэлтийг цахимаар бүртгэн шийдвэрлэв. Усны мэдээллийн сан, газрын доорх усны хяналт-шинжилгээний сангийн мэдээллийг баяжуулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт 91.1 хувьтай үнэлэгдэж, цахим сувгаар 97 мэдээ, мэдээлэл түгээж, олон нийтэд усны салбарын мэдээллийг хүргэн ажиллав.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь
21	Арга хэмжээ 9.1.Улсын усны мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хөтлөх, шинэчлэх үйл ажиллагааг зохион байгуулах	-	-	Мэдээллийг санд оруулсан хувь /өссөн дүнгээр/	20	30	Улсын усны мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хөтлөх, шинэчлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, усны нөөц, ашиглалт, хяналт-шинжилгээтэй холбоотой мэдээллийг цахим системд төвлөрүүлэн бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн хүсэлтийг www.ewater.mn цахим системээр хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд нийт 498 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг бүртгэн, холбогдох мэдээллийг системд оруулж, мэдээллийн санг тогтмол шинэчилсэн. Мөн Улсын усны мэдээллийн сан (www.infowater.mn)-г баяжуулах, мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор усны салбарын мэдээллийг нэгтгэн бүрдүүлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулсан. Газрын доорх усны хяналт-шинжилгээний нэгдсэн сан (www.groundwater.mn)-д хяналт-шинжилгээний мэдээллийг төвлөрүүлэн оруулах, санг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж ажилласан. Түүнчлэн 2026 оны 05 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр усны мэдээллийн цахим сангуудын үйл ажиллагаа, ашиглалтын талаар олон нийтэд мэдээлэл хүргэж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Ингэснээр Улсын усны мэдээллийн сан болон газрын доорх усны хяналт-шинжилгээний нэгдсэн сангийн мэдээллийг тогтмол бүрдүүлж, шинэчлэх ажлыг зохион байгуулан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг усны салбарын шаардлагатай мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан болно.	100

22	Арга хэмжээ 9.2.Усны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, нээлттэй өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлэх	-	-	Мэдээллийн ил тод байдлын шалгуурын хувь /өссөн дүнгээр/	70	75	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Усны газрын даргын 2024 оны А/181, А/182 дугаар тушаалуудыг гарган мэдээллийг өгөгдөл бий болгох, боловсруулах албан хаагчдыг томилсон. Хуулийн 8 зүйлд заагдсан мэдээлүүдийг Усны газрын веб сайт, "Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас", "Шил ажиллагаа цахим систем", "Шилэн дансны цахим систем", "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем", "Усны мэдээллийн нэгдсэн систем" болон холбогдох байгууллагын цахим систем, байгууллагын мэдээллийн самбар зэрэг олон нийтэд нээлттэй мэдээллийн эх сурвалжуудад мэдээллийг байршуулсныг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын дагуу урьдчилсан байдлаар үнэлж, тайланг гаргахад 91.1 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Усны газрын веб сайт болон "facebook.com/MongolianWaterAgency" цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан усны талаарх мэдээллийг олон нийтэд түгээх хүрээнд нийт 97 пост, мэдээлэл нийтэлж, усны нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалт, усны салбарын бодлого, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн ажилласан. Тайланг хугацаанд тус пэйж хуудас 1,108,969 хандалт, 268,663 хэрэглэгчийн үзэлт, 64,106 удаагийн 3 секундний видео үзэлт, 1,992 удаагийн 1 минутын видео үзэлт авч, нийт хандалтын 67.3 хувь нь дагагч бус хэрэглэгчдээс бүрдсэн байна. Энэ нь байгууллагын мэдээлэл зөвхөн дагагч хэрэглэгчдэд бус өргөн хүрээний олон нийтэд хүрч, усны салбарын талаарх мэдээлэл, мэдлэгийг түгээх ажлын үр нөлөө, хүртээмж нэмэгдэж байгааг харуулж байна.</p>	100
23	Арга хэмжээ 9.4.Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах		Төсөл, хөтөлбөр	Арга хэмжээний тоо /өссөн дүнгээр/	-	Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг зохион байгуулсан байна.	<p>Усны газраас Дэлхийн усны өдрийг тохиолдуулан олон улсын байгууллага, төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, залуучуудын оролцоог хангасан олон талт арга хэмжээг зохион байгууллаа.</p> <p>НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), НҮБ-ын Өмэгтэйчүүдийн байгууллага (UN Women)-тай хамтран "Ус ба тэгш эрх / Ус ба хүйсийн тэгш оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, усны засаглал дахь эмэгтэйчүүдийн манлайлал, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл дэх усны нөөцийн тэгш хүртээмж, эдийн засгийн хариуцлагын тогтолцооны талаар хэлэлцэв. Мөн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төвлөрсөн орлогыг усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах механизмыг танилцуулсан.</p> <p>Түүнчлэн Монгол Улсын Усны нөөцийн зөвлөлийн гишүүд, инженерүүдийн оролцоотойгоор "Хэрлэн Тооно" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, ус ашиглалтын балансыг хэлэлцэж, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэв. Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний хүрээнд ашиглалтад орсон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй уялдуулан үйлдвэрлэлийн зориулалтаар гүний ус ашиглахыг үе шаттайгаар бууруулж, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг танилцууллаа.</p> <p>Арга хэмжээнд БОУАӨЯ-ны удирдлагууд, Усны газрын албан хаагчид, 21 аймгийн Сав газрын захиргааны төлөөлөл, Усны нөөцийн зөвлөлийн гишүүд болон олон улсын байгууллагуудын төлөөлөл оролцов.</p> <p>Мөн 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдөр ХААИС-д "Ус – Хөгжлийн түлхүүр" оюутны эрдэм шинжилгээний XX бага хурлыг БОУАӨЯ, Усны газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисстой хамтран зохион байгуулж, 100 гаруй эрдэмтэн, багш, оюутан усны салбарын инноваци, судалгааны үр дүнгээ хэлэлцэв.</p> <p>Үүнээс гадна "Өсвөрийн парламент-2026" загвар чуулганыг Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулж, танхимаар болон цахимаар нийт 126 өсвөрийн парламентын гишүүн оролцон усны засаглалын талаар мэдлэг олж авсан. Мөн "Youth for Water Festival 2026" арга хэмжээгээр 200 гаруй залуучууд, иргэдийг усны нөөц хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.</p>	100
Зорилт 10.	Усны салбарын мэргэжил, арга зүйн удирдлагыг бэхжүүлэх	-	-	Сургалт, зөвлөгөөний зорилтод хүрсэн хувь	-	85	<p>Усны салбарын мэргэжил, арга зүйн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд нийт 370 иргэн, ААНБ-д усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл мэдээллийн чиглэлээр зөвлөгөө өгч, www.ewater.mn системийн ашиглалтын заавар, мэдээллийг тогтмол хүргэн ажиллав. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр олон нийтэд мэдээлэл түгээж, эрх зүйн сургалт, чадавжуулах 4 удаагийн арга хэмжээг сав газрын захиргаа болон орон нутгийн байгууллагуудад зохион байгуулсан. Мөн газрын гүний усны нөхцөлийн талаарх шинжээчийн дүгнэлтийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэв. Зорилтот түвшин хангагдсан.</p>	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь

24	Арга хэмжээ 10.1.Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, чиглэл өгөх	-	-	Зөвлөгөө, ажлын чиглэлийн тоо /өссөн дүнгээр/	-	160	<p>Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллага болон иргэдэд усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл мэдээллийн чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэн ажилласан. Тайлант хугацаанд усыг зүй зохистой ашиглах, ус ашиглах эрх болон усны мэдээллийн бүртгэлийн талаар мэдээлэл авахаар хандсан 110 иргэн, 260 аж ахуйн нэгж, байгууллагад www.ewater.mn цахим системийг ашиглах заавар, зөвлөгөө болон холбогдох мэдээллийг тухай бүр хүргэж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Мөн 2026 оны 05 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан байгаль орчин, уур амьсгалын салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр олон нийтэд усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, усны мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээж, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Түүнчлэн Эрүүгийн 2414000690353 дугаартай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Баянхонгор аймгийн Заг сумын нутаг дахь "Ханангийн булаг" нэртэй газрын гүний болон гадаргын усны нөөц, урсац, ундаргын нөхцөл байдлыг тогтоох зорилгоор 2026 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд газар дээр нь ажиллаж, мэргэжлийн дүгнэлт боловсруулан БНХ0326/027 дугаар дүгнэлтийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд <b>нийт 370</b> иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, чиглэл өгч, усны салбарын мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ус ашиглалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна.</p>	100
25	Арга хэмжээ 10.2.Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн байгаль хамгаалагч, улсын байцаагч нарт усны чиглэлээр сургалт, чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	-	Сургалт, чадавхжуулах арга хэмжээний тоо /өссөн дүнгээр/	10	12	<p>Усны салбарын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангах, сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт, чадавхжуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулсан.</p> <p>2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Аствишн ХХК-тай хамтран ewater.mn цахим системд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, холбогдох журам, стандартын шинэчлэлтийг тусгасантай холбогдуулан цахим сургалт зохион байгуулж, системийн ашиглалт, бүртгэл мэдээллийн шинэчлэлийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Мөн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Орхон-Чулуут, Сэлэнгэ, Хануй, Хараа-Ерөө голын сав газрын захиргаадын мэргэжилтнүүдэд, 03 дугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн Байгаль орчны газрын хүсэлтээр нийслэлийн дүүргүүдийн татварын улсын байцаагч нарт, 03 дугаар сарын 20-ны өдөр сав газрын захиргаадын дарга, мэргэжилтнүүд болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтнүүдэд тус тус Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд усны салбарын төрийн байгууллагуудын албан хаагчдыг хамруулсан <b>нийт 4 удаагийн</b> сургалт, чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулж, усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, ус ашиглалт болон ус бохирдуулсны төлбөрийн бүртгэл, тайлагналтын талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	100
Зорилт 11. Байгууллагын бодлого, төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг сайжруулах	-	-	Төсвийн хэрэгжилтийн хувь	-	90	Төсвийн хэрэгжилт 90 хувийн зорилтын хүрээнд бодлогын баримт бичгүүдийн 21 чиг үүргийн хэрэгжилт, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, тайланг холбогдох байгууллагад хугацаанд хүргүүлэв. 2025 оны санхүүгийн тайланг аудитад хүргүүлж баталгаажуулсан бөгөөд 2026 оны худалдан авах ажиллагааны хүрээнд 7 төсөл, арга хэмжээнээс 6-т гэрээ байгуулан хэрэгжилтийг эхлүүлэв. Төсвийн гүйцэтгэлийг сар бүр тайлагнаж, шилэн дансны мэдээллийг 100 хувь хугацаанд нь байршуулж, санхүү, хөрөнгийн бүртгэл, тооллого, шилжилт хөдөлгөөнийг сайжруулан байгууллагын санхүүгийн ил тод, тогтвортой байдлыг ханган ажиллав.	Зорилтын дундаж үнэлгээ 100 хувь	

26	Арга хэмжээ 11.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, хэрэгжилтийг хангах, үнэлгээ хийх	-	-	Хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайлангийн тоо /өссөн дүнгээр/	-	3	"Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого /20 арга хэмжээ/, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /8 арга хэмжээ/, Шинэ сэргэлтийн бодлого /2 арга хэмжээ/, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /4 арга хэмжээ/ зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 21 чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2026 оны 144 дүгээр тогтоолоор эдгээр бодлогын баримт бичгүүдийг тайлагнах цагалбарт өөрчлөлт оруулан 1-5 жилээр тайлагнахаар заасан тул 2026 оны эхний хагас жилийн тайлан гараагүй болно. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох байгууллагад хүргүүлсэн. 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. 2. 2026 оны хяналтад авагдсан 21 заалтын хэрэгжилтийн I улирлын тайланд үнэлгээ хийж, 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд цахимаар хүргүүлсэн. 3. Байгууллагын хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.	100
27	Арга хэмжээ 11.2.Төсвийн шууд захирагчийн төсөв, хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэх	-	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Төсвийн тухай хуулийн 8.8.1-д заасны дагуу Усны газрын 2026 оны 1-6 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуульд заасан хугацаанд БОУАӨЯ-ны Төрийн санд хүргүүлж, байгууллагын удирдлагыг төсвийн гүйцэтгэлийн мэдээллээр тогтмол ханган ажилласан. Түүнчлэн санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хоёрдугаар гарын үсэг зурж, байр ашиглалт, дотоод томиллолт, хангамжийн бараа материал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг батлагдсан төсөв болон сарын хуваарийн хүрээнд хянаж баталгаажуулан, холбогдох төлбөр тооцооны гүйлгээг Төрийн сангаар дамжуулан цаг тухайд нь гүйцэтгэж, байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.	100
28	Арга хэмжээ 11.3.Төсвийн шууд захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах	-	-	Тайлангийн тоо /өссөн дүнгээр/	1	1	Усны газрын 2025 оны төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2026 оны 01 сарын 19 өдрийн 01/35 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, и-тайланд шивж тайлагнасан байна. Аудит хийсэн санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 25-ний өдрийн 01/131 тоот албан бичгээр БОУАӨЯ-д хүргүүлж баталгаажуулсан.	100
29	Арга хэмжээ 11.4.Агентлагийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах	-	-	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан хувь /өссөн дүнгээр/	-	Холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг 40-өөс доошгүй хувьтай хангаж ажилласан байна.	Агентлагийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 2026 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. "УТ2601300705 Хөв цөөрөм барих" төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Богд суманд Эко Буянт ХХК, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд Энх Өргөө ХХК, Өмнөговь аймгийн Баяндалай суманд Хүйс Нутаг ХХК-тай 2026 оны 4 дүгээр сард тус тус гэрээ байгуулсан. "УТ2601301004 Онги-Цагаан Бургастай" төслийн хүрээнд ТЭЗҮ боловсруулах ажлыг Монхидро Констракшн ХХК, ажлын зураг төсөв боловсруулах ажлыг Хайдродизайн Проект ХХК гүйцэтгэхээр 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр гэрээ байгуулсан. Харин БОНБНҮ хийх тендерт шаардлага хангасан оролцогч шалгараагүй. "УТ260131003 Усны хээрийн хяналт-шинжилгээний багаж, төхөөрөмж нийлүүлэх" тендерт Хөх Хөхтий ХХК шалгарч, 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр гэрээ байгуулсан. Нийт 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгдөж, 6 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулаад байна.	100
30	Арга хэмжээ 11.5.Агентлагийн ажилчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнах	-	-	Тайлангуудыг тухай бүрд нь тайлагнасан байх /өссөн дүнгээр/	-	6	Ажилтнуудын цалин хөлсийг цагийн бүртгэл, холбогдох тушаал шийдвэр болон бусад анхан шатны баримт бичигт үндэслэн тооцож, Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд бүрэн олгосон. 2026 оны 1-5 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан болон I улирлын хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд тайлагнан баталгаажуулсан Нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр үүсгээгүй болно	100
31	Арга хэмжээ 11.6. Байгууллагын хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн нийлүүлэлт, төсвийн зарцуулалтыг ил тод, үр ашигтай байлгах	-	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь	-	Шилэн дансны системд мэдээлэл орсон хувь 100 хувь	Төсвийн шууд захирагчийн 2025 оны 12 дугаар сар болон 2026 оны 1-5 дугаар сарын төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой нийт 87 мэдээллийг Шилэн дансны цахим системд хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж, хуулиар мэдээлэхээр заасан мэдээллийг 100 хувь хугацаанд нь байршуулсан тул арга хэмжээ бүрэн хэрэгжсэн.	100

32	Арга хэмжээ 11.7. Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл хяналтыг сайжруулах, шинэчлэл хийх	-	-	Ажлын удирдамж, төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	-	Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, шинэх хүрээнд ажлын удирдамж, төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна.	Байгууллагын өмч, эд хөрөнгийн бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр "Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах" 6 заалттай төлөвлөгөө боловсруулж 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр батлан дараах ажлуудыг хэрэгжүүлэв. -Усны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, балансын үнэ 754.0 мянган төгрөгийн 1 ширхэг принтерийг Онон-Улз голын сав газрын захиргаанд балансаас балансад шилжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А-1/439 дугаар зөвшөөрлийг авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. -Санхүү, хөрөнгийн бүртгэлийн шинэ системд шилжих ажлын хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаарх хөрөнгийн бүртгэл, санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн мэдээллийг тулган баталгаажуулах ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны дотор бүрэн зохион байгуулж ажилласан. -Төрийн өмчийн эд хөрөнгийн 2026 оны улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах хүрээнд А/71 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулж, комиссын бүрэлдэхүүнийг батлуулан, удирдамж, төлөвлөгөө боловсруулж, батлуулсан бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Ингэснээр байгууллагын өмч, эд хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, тооллого, хяналтын ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.	100
Зорилт 12. Хүний нөөцийн чадавх, албан хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах		17.5	Улсын төсөв	Хүний нөөцийн бодлого, ёс зүйн арга хэмжээний гүйцэтгэл	-	80	Хүний нөөцийн чадавх, албан хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд нийт 370 иргэн, ААНБ-д зөвлөгөө мэдээлэл өгч, ewater.mn системийн сургалт зохион байгуулан, 4 удаагийн чадавхжуулах сургалтаар сав газар болон орон нутгийн байгууллагын албан хаагчдыг хамруулав. Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, ХАБЭА, галын аюулгүй байдлын сургалт зохион байгуулсан. Нийгмийн баталгааг хангах хүрээнд буцалтгүй тусламж, дэмжлэг олгож, хүний нөөцийн мэдээллийг 100 хувь шинэчлэн, ёс зүй, авлигын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр зорилтот түвшин 85 хувьд хүрсэн.	Зорилтын дундаж үнэлгээ 99 хувь
33	Арга хэмжээ 12.1.Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт боловсруулж, хэрэгжилтийг хангах	-	-	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь /өссөн дүнгээр/	-	80	Тайлант хугацаанд албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, хэрэгжилтийг тогтмол ханган ажилласан. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, манлайлах болон удирдах чадамжийг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн Тэргүүн түшмэлийн болон Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Мөн албан хаагчдын хувь хүний хөгжил, ажлын бүтээмж, сэтгэл зүйн дархлааг бэхжүүлэх чиглэлээр бизнесийн удирдлага, сэтгэл зүйч Д.Цэцэнбилэгийг урьж "Амьдрах стратеги" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Албан хаагчдын гадаад хэлний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Испани хэлний сургалтад хамруулах 4 албан хаагчийн нэрсийг холбогдох журмын дагуу Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр газрын 34 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж, ипотекийн зээлийн дэмжлэг болон түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн. Түүнчлэн усны салбарын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 21 сав газрын захиргааны 185 албан хаагч, Цаг уур, орчны шинжилгээний газрын усны харуулын 182 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож ажлыг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын сургалт, хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт тайлант хугацаанд 85 хувьд хүрч, төлөвлөсөн зорилтот түвшинг ханган ажилласан.	100
34	Арга хэмжээ 12.2.Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг оруулах, боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол шуурхай зохион байгуулах	-	-	Удирдлага мэдээллийн системд төрийн албан хаагчдын мэдээллийг оруулсан хувь	-	100	2026 оны эхний хагас жилийн байдлаар тус газрын төрийн захиргааны 15, төрийн үйлчилгээний 13, нийт 28 албан хаагчийн хувь хүний мэдээлэл, боловсрол, мэргэжил, мэргэшил, ажлын туршлага, шагнал урамшуулал, томилгоо, чөлөөлөлт болон шилжилт хөдөлгөөний мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд тухай бүр шинэчлэн оруулж, баталгаажуулсан. Ингэснээр хүний нөөцийн мэдээллийн бүрдүүлэлт 100 хувь хангагдсан. Тайлант хугацаанд нийт 9 албан хаагчийн томилгоо, шилжилт хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэснээс 1 албан хаагчийг шинээр томилж, 8 албан хаагчийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу албан тушаалд шилжүүлэн томилсон. Мөн 5 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлснөөс 3 нь өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөж, 1 нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон, 1 нь урт хугацааны чөлөө авсан байна.	100
35	Арга хэмжээ 12.3.Төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах, үр дүнтэй ажилласан албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгох	-	-	3 сараас дээш хугацаагаар ажилласан төрийн албан хаагчдад урамшуулал олгосон хувь	-	100	Байгууллагын төсөвт албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг тусгаж батлуулсан. Албан хаагчдын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хийхээр төлөвлөсөн тул хугацаа болоогүй байна.	90

36	Арга хэмжээ 12.4. Мэргэшүүлэх сургалт, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	-	-	Удирдах, гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан тоо /өссөн дүнгээр/	13	14	Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд 2026 оны эхний хагас жилд Удирдлагын академийн Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Газрын дарга З.Батбаяр болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болор-Эрдэнэ нар хамрагдсан болно.	100
37	Арга хэмжээ 12.5. Албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын орчныг сайжруулах	17.5	Улсын төсөв	Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсан албан хаагчдын хувь	-	100	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн эрсдэлийг эрт илрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажилласан. Энэ хүрээнд 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр "Интернэйшнл Медикал Сентер" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, багц шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан.	100
		-	-	Хөдөлмөрийн аюулгүй байдлын орчныг сайжруулах хүрээнд зохион байгуулсан ажлын тоо /өссөн дүнгээр/	-	1	Албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг боловсруулж, 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж эхэлсэн. Батлагдсан журмын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг танилцуулж, ажлын байран дахь аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн. Мөн Онцгой байдлын ерөнхий газарт хүсэлт хүргүүлсний дагуу Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсээс гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын байранд сургалт зохион байгуулж, албан хаагчдын гамшиг, ослын үеийн бэлэн байдал, мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. Ингэснээр байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод зохицуулалтыг бүрдүүлж, албан хаагчдын аюулгүй ажиллах орчин, урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг сайжруулах чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.	100
38	Арга хэмжээ 12.6. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах	-	-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээгээр танилцуулга, мэдээлэл хийсэн байна.	2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр нийт албан хаагчдад Усны газрын 2025 оны Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний үр дүнг танилцуулсан. Тус үнэлгээгээр Усны газар нийт 10 онооноос 6.7 оноо авч үнэлэгдсэн бөгөөд оноонд хамгийн их нөлөөлсөн үзүүлэлт нь "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдэн, авах боломжит 4 онооноос 1.7 оноо авсан байна. Иймд ёс зүйн асуудлаар албан хаагчдын оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор байгууллагын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд улирал бүр нэг хэлтэс ёс зүй, соён гэгээрүүлэх чиглэлийн арга хэмжээ зохион байгуулахаар тусган хэрэгжүүлж байна. Мөн Ёс зүйн хорооноос эмхэтгэн гаргасан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн эмхэтгэл"-ийг нийт албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглах, түүнчлэн хэлтсүүдээс зохион байгуулах сургалт, мэдээлэл, соён гэгээрүүлэх арга хэмжээнд ашиглах талаар зөвлөмж хүргүүлсэн.	100
39	Арга хэмжээ 12.7. Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтэс бүр 1 арга хэмжээг зохион байгуулахаар нэгжийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх	-	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Ус ашиглалт технологийн хэлтэс тус бүр 1 арга хэмжээ зохион байгуулсан байна	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр байгууллагын хэмжээнд дараах арга хэмжээг зохион байгууллаа. Усны газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/3 дугаартай албан бичгээр Ёс зүйн дэд хорооны 2025 оны ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт, тайланг нийт албан хаагчдад цахим системээр хүргүүлж, үнэлгээний үр дүнг танилцуулсан. 2026 оны 01 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ"-г батлагдсан аргачлалын дагуу хийж танилцуулсан. Мөн албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, стресс, бухимдлаас урьдчилан сэргийлэх, түүнийг зөв удирдах мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сэтгэл зүйч Д.Цэцэнбилэгийг урьж, "Амьдрах стратеги" сэдэвт сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.	100

40	Арга хэмжээ 12.8.Авлигын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө"-г боловсруулж хэрэгжүүлэх	-	-	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	-	"Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан байна.	2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан khulbur.iaas.mn цахим ситстемээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 онд нийт 5 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан.Тухайлбал: Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Албан хаагчдад ёс зүй, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сургалт зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн амхэтгэл"-ийг хүргүүлсэн. Усны газрын 2025 оны ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний үр дүнг нийт албан хаагчдад танилцуулж, эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж өгсөн. Ёс зүйн хорооны баталсан аргачлалын дагуу байгууллагын албан тушаалуудад ёс зүйн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл өндөртэй чиг үүргийг тодорхойлон урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөсөн. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаар мэдээлэл, зөвлөмжийг цахим хэлбэрээр тогтмол түгээж, сав газрын захиргааны албан хаагчдад сургалт, арга зүйн зөвлөгөө өгсөн. Төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж, хэрэгжилт 100 хувьтай байна.	100
41	Арга хэмжээ 12.9.Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтэс бүр 1 арга хэмжээг зохион байгуулахаар нэгжийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх	-	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Усны нөөцийн менежмент, төлөвлөлтийн хэлтэс, Усны чанар, шинжилгээний хэлтэс тус бүр 1 арга хэмжээ зохион байгуулсан байна.	Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд Усны чанар, шинжилгээний хэлтэсээс нэгжийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 2026 оны нэгдүгээр улиралд авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөмжийг байгууллагын цахим систем болон цахим хуудсаар дамжуулан албан хаагчид болон олон нийтэд 2 удаа түгээн сурталчилсан. Усны нөөцийн менежмент, төлөвлөлтийн хэлтэсээс нэгжийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Алтайн Өвөр говийн сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүдэд зориулан авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч, мэргэжил, арга зүйн зөвлөгөө хүргэсэн байна.	100
42	Арга хэмжээ 12.10.Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу зохион байгуулж, ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	-	Эрсдэлийн тооцох үнэлгээ хийгдсэн байдал (Тийм-1, Үгүй-0)	-	1	Ёс зүйн хорооны баталсан аргачлалын дагуу байгууллагын нийт албан тушаалыг хамруулан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ 2026 оны 01 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд хийж, эрсдэл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг тодорхойлов. Үнэлгээг албан тушаалын эрх мэдэл, шийдвэр гаргалт, мэдээлэл ашиглалт, ашиг сонирхлын зөрчил, иргэн, аж ахуйн нэгжтэй харилцах харилцаа, удирдлагын хяналт, ил тод байдал, сахилга хариуцлага, байгууллагын соёл зэрэг 9 үзүүлэлтээр үнэлсэн. Үр дүнд нь шийдвэр гаргах, дүгнэлт гаргах, мэдээллийн сантай ажиллах, иргэн, хуулийн этгээдтэй шууд харилцах чиг үүрэг бүхий албан тушаалуудад ёс зүйн эрсдэл харьцангуй өндөр байгааг тогтоосон тул ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулах, урьдчилан сэргийлэх хяналтыг сайжруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна.	100
<b>Зорилт 13.</b> Олон Улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хилийн усыг ашиглах, хамгаалах хэлэлцээрийг хэрэгжүүлэх		150.0	Улсын төсөв	Олон улсын хамтын ажиллагааны арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	90	Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Монгол-Хятадын хилийн усны хамтарсан комиссын мэргэжилтнүүдийн ажлын хэсгийн XIII хурлын бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудал, материалыг боловсруулан оролцогч талуудад хүргүүлэв. COP17 бага хурлыг угтан НҮБ, ЮНЕСКО-тай хамтран ус, хөрс хамгаалалт, газрын доорх усны нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулж, "Ус-Хөгжлийн түлхүүр" эрдэм шинжилгээний хурлын үр дүнг олон улсад танилцуулахаар бэлтгэв. Говийн бүсэд саарал ус ашиглалтыг нэмэгдүүлэх, экосистемийн хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хилийн усны хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлж байна.	Зорилтын дундаж үнэлгээ 95 хувь
43	Арга хэмжээ 13.1.Хилийн усыг хамгаалах, ашиглах Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хилийн усны ажлын хэсэг, шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулах	150.0	Төсөл, хөтөлбөр	Хамтарсан шинжээчдийн багийн протокол Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол	2	Бүрэн эрхт төлөөлөгчдийн хэлэлцээрийг зохион байгуулж, протокол-1 үйлдсэн байна.	Монгол, Хятадын хилийн усны хамтарсан комиссын хамтарсан мэргэжилтнүүдийн ажлын хэсгийн XIII хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хуралдааны тов, хэлэлцэх асуудал, холбогдох материалыг боловсруулан оролцогч талуудад хүргүүлсэн. Гэвч хамтран оролцогч байгууллагын шалтгаанаар хурлыг 2026 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод зохион байгуулахаар товлоод байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хурлыг товлосон хугацаанд зохион байгуулахаар ажиллаж байна.	90

44	Арга хэмжээ 13.2.Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд оролцох	-	-	Зохион байгуулалтын хүрээнд хариуцсан ажлын гүйцэтгэлийн хувь /өссөн дүнгээр/	-	90	2026 оны 8 дугаар сарын 17–28-ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулагдах НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (UNCCD COP17)-ыг утган Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. COP17 хурлын хүрээнд 8 дугаар сарын 25-ны өдрийг "Усны өдөр" болгон зохион байгуулахаар төлөвлөж, ЮНЕСКО-гийн Олон улсын ус зүйн хөтөлбөртэй хамтран уур амьсгалын өөрчлөлтийн үеийн ган гачгийн эрсдэлийг бууруулах, газрын доорх усны нөөцийг хамгаалах чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулах бэлтгэлийг хангаж байна. Мөн НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын удирдлагуудтай хийсэн уулзалтаар Монгол Улсын ус, хөрс хамгаалалтын стратегийг танилцуулж, COP17-д хэлэлцүүлэх асуудлуудыг эцэслэн тохиролцсон. Усны газар нь цөлжилт, газрын доройлтыг бууруулах зорилгоор говийн бүсийн уул уурхай, үйлдвэрүүдэд саарал ус ашиглах, гүний цэнгэг усны хэрэглээг бууруулах чиглэлээр удирдамж боловсруулан хэрэгжилтэд хяналт тавьж байна. Түүнчлэн гол мөрөн, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг хэрэгжүүлж, Сав газрын захиргаатай хамтран экосистемийн хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авч байна. Мөн "Ус-Хөгжлийн түлхүүр" оюутны эрдэм шинжилгээний XX бага хурлаар шалгарсан судалгааны ажлуудыг COP17 хурлын үеэр олон улсад сурталчлахаар бэлтгэж байгаа бөгөөд ЮНЕСКО-гийн дэлхийн сүлжээнд бүртгэлтэй усан сан бүхий болон байгалийн цогцолборт газруудыг уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хурлаар танилцуулахаар ажиллаж байна.	100
45	Арга хэмжээ 13.3.Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах	-	-	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	Зохион байгуулагдсан олон улсын арга хэмжээнд бүрэн хамрагдсан байна.	Усны салбарт хамтран ажиллах, газар доорх усны хяналт шинжилгээ, менежментийн арга хэрэгслийг хөгжүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцох, сургалт, семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж Бүгд Найрамдах Франц улсын Геологи, уул уурхайн судалгааны байгууллагатай хамтын ажиллагааны мэдэгдлийг, Бүгд Найрамдах Солонгос улсын Байгаль орчны Корпораттай харилцан туршлага солилцох, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагааг хэрэгжүүлэх санамж бичгийг, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Захсен Муж улсын Фрайберг хотын "Уул уурхайн академи" техникийн их сургуультай Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, зүй зохистой ашиглах, ган, цөлжилт, хуйрайшилтын эрчимжилтийг бууруулах зорилгоор усны хуримтлалыг бий болгох, байгаль орчин, усны салбарын хүний нөөцийг чадавхжуулахад хамтран ажиллах санамж бичгийг тус тус байгуулан ажиллаж байна. Бүгд Найрамдах Сенегал Улсын Дакар хотод 2026 оны 01 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан НҮБ-ын Усны бага хурлын бэлтгэл ажлыг хангах өндөр түвшний уулзалтад мөн Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2026 оны 5 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссоос зохион байгуулагдсан "Хил дамнанас сав газрын мониторинг, үнэлгээ, мэдээлэл солилцоонд шинэ технологи, инновацыг ашиглах нь" семинар болон "Мониторинг, үнэлгээний ажлын хэсгийн 21 дүгээр хуралдаан"-нд Усны газрын дарга З.Батбаяр оролцож ажилласан.	100
	Зорилт 14. Үйл ажиллагааны тасралтгүй, хүртээмжтэй хурдан шуурхай байдлыг хангаж, үйл ажиллагааг цахимжуулах	-	-	Төрийн үйлчилгээ, дотоод үйл ажиллагааны цахимжилтын хувь	-	85	Үйл ажиллагааны цахимжилт, шуурхай байдлыг хангах хүрээнд албан хэрэг хөтөлөлтийн журмыг шинэчлэн баталж, архив, баримт бичгийн бүртгэл, хяналтыг цахимжуулан 593 албан бичиг, 36 өргөдөл гомдлыг хугацаанд шийдвэрлэв. www.ewater.mn системээр 498 хүсэлтийг цахимаар хүлээн авч, ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг 100 хувь цахимаар олгож, үйлчилгээний цахимжилт 88.6 хувьд хүрэв. ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх хүрээнд 29 арга хэмжээ хэрэгжүүлж, 10 процессын зураглал боловсруулан байгууллагын дотоод үйл ажиллагааны цахим болон чанарын удирдлагын тогтолцоог сайжруулав. Зорилтот түвшин хангагдсан.	Зорилтын дундаж үнэлгээ 99 хувь
46	Арга хэмжээ 14.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэх ажлын үр дүнг сайжруулах			Ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх хугацаа /хугацааг бууруулсан дүнгээр/	Хууль, тогтоомжид зааснаар 7-30 хоногт шийдвэрлэнэ	Дунджаар 15 хоног	2026 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 6 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар нийт 593 албан бичиг ирснээс 424-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 169 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, судлагдаж байна. Мөн тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 30 өргөдөл, гомдол, хүсэлт, Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан 6 санал, хүсэлт ирүүлсэн бөгөөд нийт 36 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 26-г шийдвэрлэж, 10 нь хуулийн хугацаа болоогүй, судлагдаж байна. Ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг дунджаар 14 хоногийн дотор хүргэн ажилласан бөгөөд шийдвэрлэлтийн шуурхай байдлыг хангаж ажиллав.	100

47	Арга хэмжээ 14.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-д нийцүүлэн байгууллагын албан хэрэг хөтөлтийн журмыг боловсруулан, батлах			Батлагдсан журам	-	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын албан хэрэг хөтөлтийн журмыг боловсруулан, баталсан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-д нийцүүлэн байгууллагын албан хэрэг хөтөлтийн журмыг боловсруулж Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/58 дугаартай "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам батлах тухай" тушаалаар баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
48	Арга хэмжээ 14.3.Хэлтсүүдээс Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.2, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр нэгжийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх	-	-	Нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь /өссөн дүнгээр/	-	Эхний хагас жилийн биелэлт 85 хувиас багагүй байна.	Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар архив, албан хэрэг хөтлөлт, бүртгэл, хяналтын ажлыг сайжруулах зорилгоор албан хаагчдын чиг үүргийг тодорхой хуваарилан, хурлын тэмдэглэл, удирдлагын үүрэг даалгавар, гэрээ, санамж бичиг, томилолт, өргөдөл, гомдол, тушаал шийдвэр, ажлын хэсэг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн бүртгэл, хяналт, цахим архивын сан бүрдүүлэх ажлыг албан хаагчдад хариуцуулан хэрэгжүүлж байна. Архивын улсын үзлэгийн дүгнэлтэд тусгагдсан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын дагуу 10 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Мөн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд нийцүүлэн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмыг боловсруулж, газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна. Тайлант хугацаанд газрын хэмжээнд ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллахад нийт 593 албан бичиг хүлээн авснаас 424-ийг шийдвэрлэж, 169 нь шийдвэрлэх хугацаа болоогүй судлагдаж байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 36 өргөдөл, гомдлоос 26-г шийдвэрлэж, 10 нь хугацаа болоогүй байна. Албан бичиг, өргөдөл, гомдлын хариуг дунджаар 14 хоногийн дотор хүргүүлж, шийдвэрлэлтийн шуурхай байдлыг ханган ажилласан байна. 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар А тушаал-70, Б тушаал-15 гарсан бөгөөд архив, албан хэрэг хөтлөлтийн бүртгэл, хяналтын тогтолцоо сайжирч, баримт бичгийн шийдвэрлэлтийн үр нөлөө дээшилсэн байна.	100
49	Арга хэмжээ 14.4.Архивын улсын үзлэгийн дүгнэлтэд дурдсан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	-	-	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь /өссөн дүнгээр/	-	Төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан гүйцэтгэл эхний хагас жилд 85 хувиас багагүй байна.	2025 оны Архивын улсын үзлэгийн дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж, 2026 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмыг боловсруулж, Газрын даргын 2026 оны А/58 дугаар тушаалаар батлуулсан. Архивын нэгж баримт хүлээн авах хуваарь, зохион байгуулалтын бүтцийн нэгж болон албан бичигт гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны индексийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Мөн 2026 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Байгууллагаас байгуулсан хамтран ажиллах гэрээ 14, санамж бичиг 5-ын бүртгэлийг хөтөлж, архивын нэгж болгон хадгалах бэлтгэлийг хангаж ажилласан. Иргэн, байгууллагын хүсэлтийн дагуу олгосон 125 архивын лавлагааны бүртгэлийг хөтөлж, архивын баримтын бүрдүүлэлтийг ханган ажиллав. Архивын баримт хадгалах зориулалтын нягтаршуулсан 4 ширхэг шүүгээг 6.0 сая төгрөгөөр худалдан авч, архивын өрөөг стандартад нийцүүлэн тохижуулах ажлыг эхлүүлсэн. Байгууллагын түүхчилсэн лавлахыг боловсруулах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 2026 оны хоёрдугаар хагас жилд хэвлүүлэхээр бэлтгэл хангаж байна. Түүнчлэн баримт бичгийн эргэлтэд тогтмол хяналт тавьж, 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар 9,200 баримт бичиг, 150 тушаалын бүртгэлийг хөтөлж, байгууллагаас гарсан 400 албан бичгийг тухай бүр цахим баримт бичгийн системд бүртгэн оруулж, мэдээллийн бүрэн бүтэн байдал, архив, албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагааг ханган эхний хагас жилийн шалгуурыг бүрэн хангаж ажилласан	100
50	Арга хэмжээ 14.5.Эрсдэлийн удирдлагын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулан, хэлтсийн эрсдэл хариуцсан ажилтныг томилон, эрсдэлийн удирдлагын багт ажиллуулах	-	-	Эрсдэлийн удирдлагын баг томилогдсон байдал (Тийм-1, Үгүй-0)	1		Усны газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/67 дугаартай тушаалаар байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус Эрсдэлийн удирдлагын хороо байгуулан бүрэлдэхүүнийг баталсан. Тус хорооны бүрэлдэхүүнд хэлтэс, нэгжүүдийн эрсдэл хариуцсан албан хаагчдыг оролцуулан томилж, эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, эрсдэлийн үнэлгээ зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Иймд байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын баг (хороо) байгуулагдан ажиллах нөхцөл бүрдсэн.	100

51	Арга хэмжээ 14.6.Усны мэдээллийн нэгдсэн систем /ewater.mn/-ийг хөгжүүлж усны салбараас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	-	-	Цахим системээр үзүүлж байгаа үйлчилгээний хувь	-	"Усны мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэх ажлыг зохион байгуулж нийт Сав газрын захиргаа, байгаль орчны газруудыг 90-өөс доошгүй хувьд системд холбосон байна.	Усны мэдээллийн нэгдсэн систем (www.ewater.mn)-ийг хөгжүүлэх, усны салбарын төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд тайлант хугацаанд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Хаягдал усны дүгнэлтийг 100 хувь цахимаар олгож байгаа бөгөөд эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан 2026 оны 01 дүгээр сарын 02-ноос 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Аствишн ХХК-тай хамтран бохирдуулагч ангиллын үйлдвэрүүдийн ус бохирдуулсны төлбөрийн тооцооллын процессыг бүрэн цахимжуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас www.ewater.mn системээр ирүүлсэн боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах нийт 498 хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлага хангаагүй 133 төсөлд засварлах зөвлөмж, дүгнэлт гаргах боломжгүй 83 төсөлд татгалзсан хариуг системээр хүргүүлж, 233 аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргасан. Одоогоор 49 хүсэлт боловсруулах, хянуулах шатанд байна. Ус ашиглуулах дүгнэлтийн үйлчилгээг Усны газар болон сав газрын захиргаад 100 хувь цахимаар үзүүлж байна. Аймаг, нийслэлийн байгаль орчны байгууллагуудаас Төв, Говьсүмбэр, Баянхонгор, Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудаас бусад нь 100 хувь цахимаар шийдвэрлэж байгаа бөгөөд улсын хэмжээнд үйлчилгээний 88.6 хувь нь бүрэн цахимжсан байна.	95
52	Арга хэмжээ 14.7.Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	-	-	Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь /өссөн дүнгээр/	-	Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилт 60 хувиас багагүй байна.	Усны газрын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагааг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх, процессын удирдлагыг төлөвшүүлэх, чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр нийт 29 арга хэмжээг тусгасан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тамга, тэмдэг хариуцах, гарын үсгийн эрх бүхий албан тушаалтны индекс тогтоох, хөдөлмөрийн дотоод журам, зайнаас болон уян хатан цагийн зохицуулалтын журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам, албан хэрэг хөтлөлтийн журам, эрсдэлийн удирдлагын хороог байгуулах зэрэг 8 тушаал, журмыг батлан мөрдүүлсэн. Мөн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 10 процессын зураглалыг боловсруулж, баримтжуулсан мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн. Түүнчлэн Усны газрын албан томилолт, ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлт, ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах журмуудыг боловсруулж байна. Ингэснээр ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 60 хувиас дээш түвшинд хүрч, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндэс бүрдсэн.	100
<b>Нийт хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв</b>		<b>12,891.2</b>		<b>Нийт 14 зорилтын хүрээнд 52 арга хэмжээний хэрэгжилт</b>			<b>99</b>	

**ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.БУЯННЭМЭХ  
2026 оны ..... сарын .....

**ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: Төсвийн Шууд захирагч**

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.БАТБАЯР